

ХУ ЖИНТАО БА ХЯТАД-АМЕРИКИЙН ХАРИЛЦАА

*Ц.Батбаяр**

БНХАУ-ын дарга Ху Жинтао 2006 оны 4 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд АНУ-д 4 хоног айлчлав. Тэрээр БНХАУ-ын дэд дарга байхдаа 2002 онд АНУ-д анх удаа очиж байсныг эс тооцвол БНХАУ-ын дарга болсноос хойш АНУ-д хийж байгаа анхны айлчлал учраас дотооддоо төдийгүй дэлхий нийтийн анхаарлыг татсан айлчлал боллоо. Хоёр тал айлчлалын протоколын асуудлаар нэлээд зөрчилтэй байсан тухай хэвлэлүүд бичив. Хятадын ГХЯ айлчлалыг “төрийн айлчлал” хэмээн, их буугаар 21 удаа ёслолын буудлага хийж, төрийн хүндэтгэлийн оройн зоог бариулахаар чармайжээ. Харин Америкийн Төрийн департамент Ху Жинтаог Бушийн Техас дахь Кроуфорд эдлэнд урьж, хоёр Ерөнхийлөгч “зангиагүй уулзалт” хийх хувилбар дэвшүүлжээ. Эцэстээ хоёр тал харилцан буулт хийж, төрийн айлчлалын хэмжээнд авах, харин оройн зоогийн оронд үдийн зоог байхаар тохиролцсон байна. АНУ-тай эн зэрэгцэх тэнцүү жинтэй орон гэдгээ харуулах, дотооддоо нэгдүгээр хүн болсноо баталгаажуулах зорилготой Ху Жинтаогийн хувьд хүндэт харуул жагсааж, 21 удаа их буугаар ёслуулж, Цагаан ордонд Буштай уулзаж, Ерөнхийлөгчийн албан ерөөнд зургаа татуулах нь зөвхөн дипломат протоколоор хязгаарлахгүй ач холбогдолтой асуудал байлаа гэж ажиглагчид үзэж байна.¹

Сиэтлээс Вашингтонд

Ху Жинтао айлчлалаа АНУ-ын баруун эрэг, Вашингтон муж улсын нийслэл Сиэтл хотоос эхэлсэн нь хоёр талын эдийн засгийн харилцан хамаарлыг илтгэн харуулах, Америкийн бизнесийн хүрээнийхнийг “байлдан дагуулах” зорилготой байлаа. Вашингтон муж улс Хятадтай олон тэрбум ам.долларын ашигтай наймаа хийдэг Боинг онгоцны үйлдвэр, Майкрософт компани, Старбакс компани зэрэг олон арван томоохон компанитай гэдгийг Хятадын тал нарийн тооцжээ. Айлчлалын төгсгөлийг АНУ-ын дээд боловсролын нэг томоохон төв Йелийн их сургууль дээр хийх лекцээр төгсгөхөөр зохион байгуулжээ. Энэ хоёр хөтөлбөрийн дунд АНУ-ын нийслэлд болох албан ёсны уулзалтуудыг нэг ёсондоо “хавчуулж” өгсөн байна.² АНУ-ын бизнесийн нэг томоохон төв болох Вашингтон муж болон улс төрийн төв болох нийслэл Вашингтон хоёрт Ху Жинтаогийн хэлэх үгнүүдийн “давс хужрыг” тохируулж өгчээ.

Хятадын тал Ху Жинтаогийн айлчлалын гол агуулгыг “Тайваний асуудал” гэж тодорхойлж байсан бол Америкийн тал “худалдааны алдагдал, юанийн ханш, оюуны өмчийн эрхийг хамгаалах” гэж тавив.³ БНХАУ-ын Ерөнхий сайдын орлогч У И хатагтай айлчлал болохоос 7

*Ц.Батбаяр - “Өнөөгийн Хятад” сэтгүүлийн Зөвлөлийн гишүүн, доктор (Sc.D)

хоногийн өмнө АНУ-д айлчилж нийт 16,2 ам.долларын өртөгтэй 107 гэрээ, контракт байгуулав. Үүнд 4,6 тэрбум ам.долларын үнэтэй Боинг 737 онгоц 80 ширхэгийг худалдан авахаар болов. АНУ-тай худалдааны зөрчлийг намжаах үүднээс Америкийн үхрийн махыг импортоор авахаа сэргээх, Америкийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг Хятадад зарах зөвшөөрлийг олгох, Америкийн телекоммуникацийн компаниудад тэгш эрхтэй ажиллах нөхцөл олгох, Хятадын засгийн газрын тендерийг нээлттэй болгох зэрэг олон асуудлыг шийдэх амлалтууд өгсөн байна. Хоёр талын харилцаанд хамгийн ноцтойд тооцогдож байсан “оюуны өмчийн эрхийг хамгаалах” асуудлаар Хятадын тал мөн зарим бодит, дорвитой арга хэмжээ авахаар болов. Хятадад зарагдах бүх компьютерт хуулийн дагуу эрхийг нь урьдчилан худалдаж авсан софт систем суулган борлуулах тухай тохиролцоонд хүрч тодорхой хэлэлцээрүүдэд гарын үсэг зурсан байна.⁴

Ху Жинтао АНУ-д хийх айлчлалаа Сиэтл хотод байрладаг Майкрософт компаниас эхэлсэн нь санамсаргүй зүйл биш байв. Майкрософт компанийн шинэ технологийн төвтэй танилцах үеэр Ху Жинтао “Ноён Билл Гейтс та бол Хятадын найз. Би бол Майкрософтын найз. Би Майкрософтын софт системьг өдөр болгон хэрэглэдэг” гэж хэлснийг Хятадын хэвлэлүүд өргөн сурталчлав. Тус компани дээр хийсэн уулзалтууд, ялангуяа Билл Гейтсын 100 сая долларын үнэтэй хувийн шилтгээнд болсон оройн тансаг зоогийн үеэр хэлсэн үгэндээ Ху Жинтао хоёр орны худалдаа аль аль талдаа ашигтай, ялангуяа америкийн хэрэглэгчдэд ашигтай наймаа болохыг сурталчилснаас гадна “оюуны өмчийн эрхийг” хүндэтгэх талаар Хятадын Засгийн газар эрс шийдэмгий бодитой ажиллахаа илэрхийлэв.⁵

Гонконгийн “South China Morning Post” сонинд бичсэнээр “Айлчлалын гол зорилго нь өнөөгийн Хятадын талаарх америкчуудын үзэл бодлыг эерэгээр өөрчлөх явдал байв”. Ихэнх америкчууд Хятадын тухай тун бага мэдлэг, ялангуяа Хятадын өнөөгийн удирдагчид ямар үзэл бодолтой, ямар хүмүүс болох талаар төсөөлөл байхгүй. Иймд Конгрессын гишүүдтэй дотно харилцаа тогтоох, Ерөнхийлөгч Ж.Буштай харилцаагаа гүнзгийрүүлэх, Америкийн ард түмэнд өөрийгөө нээж таниулах нь Ху Жинтаогийн айлчлалын нэг чухал зорилго гэж тайлбарлажээ.⁶ Мөн Хятадын сэргэн мандал нь АНУ-д аюул занал учруулахгүй, Хятадад дотооддоо хийх шийдвэрлэх асуудал асар их байгаа учраас Хятад нь энх тайвнаар хөгжин цэцэглэхийг хүсэж байна гэсэн мессэжийг хүргэх нь Ху Жинтаогийн бас нэг чухал зорилго байсан нь тодорхой.⁷

Цагаан ордны гадна болсон төрийн ёслолын арга хэмжээний дараа Ж.Буш, Ху Жинтао нарын өргөтгөсөн яриа хэлэлцээний үеэр Тайваний асуудлаас гадна хоёр орны худалдааны алдагдлын асуудал, юаний ханш, оюуны өмчийн эрхийн асуудлуудыг хөндөн ярьсан байна. Олон улсын харилцааны асуудлаар Хойд Солонгосын цөмийн хөтөлбөр,

Иран, Ирак, мөн олон улсын терроризмын асуудлууд яригдсан бололтой.⁸ Ху Жинтао мөн АНУ-ын дэд Ерөнхийлөгч Дик Чэйни, ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга Стивэн Хэдли нартай тус тус ганцаарчилсан уулзалт хийснээс гадна Конгресс, Сенатын зарим гишүүнтэй уулзаж хоёр талын харилцааны асуудлаар санал солилцсон байна.

Тайваний асуудал хоёр орны төрийн тэргүүн нарын яриа хэлэлцээнд тодорхой байр эзэлсэн нь дамжиггүй. Ху Жинтао АНУ-д айлчлахынхаа өмнөхөн Тайваний Гоминьдан намын хүндэт дарга Лян Чаныг Бээжинд хүлээн авч уулзан, эх газар-Тайваний эдийн засгийн чуулга уулзалтыг Бээжинд зохион байгуулсан байна.⁹

Вашингтоноос Иельд

Айлчлалынхаа сүүлчийн өдөр БНХАУ-ын дарга Ху Жинтао Иель их сургуулийн (Yale University) 600 гаруй багш, оюутан, бусад зочдын өмнө лекц уншив. Тэрээр 1978 онд эхэлсэн Хятадын өөрчлөн шинэчлэлт, түүний үр дүнгийн тухай 30 гаруй минут ярьсан байна. Олсон амжилтуудаа тоо баримттай дурьдаж, ДНБ 1978 онд 147 тэрбум ам.доллар байсан бол 2005 онд 2,2 триллион болж өссөн, гадаад валютын нөөц 818 тэрбум ам.доллар болж нэмэгдсэн, 25 жилийн дотор 200 сая гаруй хүнийг ядуурлаас ангижруулсан тухай танилцуулжээ. Хэдий тийм ч Хятад улс хөгжиж буй орон хэвээр, нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээгээр дэлхийд эхний 100 орны тоонд ч багтаагүй байгааг хэлжээ. 2020 он гэхэд нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээг 3000 ам.долларт хүргэх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хөгжлийн шинэ үзэл баримтлалыг баримтлах болсноо тайлбарласан байна.¹⁰

Хятадын 5000 жилийн түүхтэй соёл иргэншил, түүний явцад бүтээсэн үнэт зүйлсүүдийн тухай голчлон ярьжээ. Ху Жинтао “эе эвийг хичээсэн нийгэм”, цаашилбал “эе эвийг хичээсэн дэлхий ертөнц” байгуулах тухай өнөөгийн Хятадын удирдагчдын үзэл бодлыг лекцэндээ ярьж тайлбарлахыг хичээсэн байна. “Эе эвийг хичээх” буюу “Harmony” гэсэн үзлийг Күнз хийгээд Күнзийн сурталтны соёл сэтгэлгээний гол цөм болох “Хэв дундыг сахихуй ёсон”-той адилтган үзэж болох ажээ. М. Чимидцээ “Хэв дундын ёсон болвоос хүмүүний ёс суртлын эрхэм дээд нь хэмээн Күнз сургаж, төр улсын төвшин тайван, түмэн олны амар амгалан, хүмүүн хоорондын харилцааны эв зохирол бүхэн “Хэв дундыг сахихуй ёсон” лугаа амин холбоотой хэмээн сургасан байдаг” гэж бичжээ.¹¹

Ху Жинтао Иель их сургуулийн багш, оюутан 100 хүнийг 2006 оны зун Хятадад хүлээн авахаар урьсан байна. Ху Жинтао ярианыхаа дараа бичгээр ирсэн нийт 78 асуултаас зөвхөн хоёрт нь хариулт өгчээ. Хятадад ардчилал, хүний эрхийг хэрхэн хангах тухай асуултад “Хятад улс улс төрийн системээ либеральчлах талаар зохих алхмууд хийж байгаа, бид гаднын тогтолцоог тэр чигээр нь хуулж авахгүй” гэсэн хариулт өгчээ.¹²

Долоо хоног тутмын “Дунфан Ляован” сэтгүүл айлчлалын үр дүнг “Ху Жинтао АНУ-ын талаарх Хятадын гадаад бодлогод шинэ үеийг нээлээ” гэж дүгнэсэн байна.¹³ “Жэньминь Жибао” сонин ч айлчлалыг нэн амжилттай айлчлал гэж дүгнэв. Юуны өмнө дэлхийн хамгийн том хөгжиж байгаа орон болон дэлхийн хамгийн баян хөгжилтэй орон хоёрын төрийн тэргүүн нар шууд нүүр тулан уулзаж учирсан явдал хоёр талын харилцаанд төдийгүй, олон улсын харилцаанд нааштай нөлөөлөл үзүүлээ гэж дүгнэв. Ху Жинтао АНУ-д дөрөв хоног айлчлах хугацаандаа Конгрессын гишүүд, төрийн түшмэд, бизнес лидерүүд, багш оюутан, эрдэмтэн судлаачдыг хамарсан нийт 32 арга хэмжээнд оролцож, 6 удаа дэлгэрэнгүй үг хэлсэн байна. “Хятад улс АНУ-ын хувьд аюул занал биш, харин итгэл үзүүлэх ёстой стратегийн түнш мөн” гэж Америкийн олон нийтэд ойлгуулахыг чармайсан гэжээ.¹⁴

Ерөнхийлөгч Ж.Бушийн БНХАУ-д хандах хандлагад ч нааштай зүйлүүд ажиглагдлаа гэж Хятадын экспертүүд үзэж байна. Ж.Буш Ху Жинтаог хүлээн авах Цагаан ордны гадаах ёслолын ажиллагаан дээр хэлсэн үгэндээ “АНУ энх тайвныг эрхэмлэдэг, хөгжин цэцэглэсэн, түүнчлэн олон улсын бүтэц институтуудыг дэмждэг Хятад орон олон улсын тавцан дээр бий болж буйг талархан хүлээн авч байна. Олон улсын системд хариуцлагатай хандаж оролцдог орнууд болохын хувьд (as stakeholders in the international system) манай хоёр ард түмэн стратегийн нийтлэг олон ашиг сонирхлыг хуваалцдаг юм” гэж хэлснийг иш татжээ. Ерөнхийлөгч Ж.Буш ноднин 9 дүгээр сард АНУ-ын ТНБД-ын орлогч Роберт Зоелликийн томъёолсон “stakeholders” гэдэг үгийг албан ёсны үгэндээ анх удаа хэрэглэснээс гадна хоёр орон стратегийн нийтлэг эрх ашгуудаар холбогддог гэдгийг мөн анх удаа хэлснийг Хятадын ажиглагчид онцлон тэмдэглэж байна.¹⁵

Хятадын судлаачид Ху Жинтаогийн энэ удаагийн айлчлалын ач холбогдлыг өндөр үнэлж, Ху, Буш нарын хооронд хувийн харилцааг тогтоож гүнзгийрүүлэх, хоёр талын харилцан итгэлцлийг бэхжүүлэх, Хятад-Америкийн харилцааны ерөнхий байдлыг тогтворжуулах ач холбогдолтой боллоо гэж үзэж байна.¹⁶

Цагаан ордны гадна болсон ёслолын үйл ажиллагааны үеэр Фалуньгун бясалгалын төлөөлөгч хашгирч Ху Жинтаогийн үгийг тасалдуулсан, Цагаан ордны зарлагч “БНХАУ” гэхийн оронд “Хятадын Бүгд Найрамдах Улс”-ын сүлд дууллыг тоглоно хэмээн андуурч зарласан, Сиегл болон бусад зарим газар Ху Жинтаогийн айлчлалын эсрэг сөрөг цуглаанууд болж байсныг эс тооцвол айлчлал ерөнхийдөө төлөвлөсөн сценарийн дагуу болж өнгөрлөө.¹⁷ Гэвч АНУ-ын шийдвэр гаргагчид өдрөөс өдөрт өргөжиж байгаа хоёр орны худалдаа-эдийн засгийн харилцааг талархан хүлээн авахын хамт Ази болон Африк, Латин Америкт ч улам бүр өргөжин тэлж буй Хятадын нөлөөллийг

хязгаарлан барих бодлого баримталж буйгаа нухгүй байна. Ху Жинтао ч энэ удаа АНУ-д хийсэн айлчлалаа цааш үргэлжлүүлж газрын тосоор баян Саудын Араб, Нигери зэрэг оронд айлчилсан нь Америкийн талд нэг зүйл сануулсан нь тодорхой.¹⁸

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Peter Brookes, Hu's not coming to dinner, <http://www.heritage.org/Press/Commentary/ed041706b.cfm?RenderforPrint=1>
2. William Pesek Jr., Beijing's practical planning: Gates first, Bush later, "International Herald Tribune", April 20, 2006.
3. Claude Barfield, The US and China: Strategic Disconnect, http://www.aei.org/include/pub_print.asp?pubID=24244
4. Trade deals reflect resolve to cut surplus, "China Daily", April 13, 2006.
5. Coffee and computers help Hu feel at home, "China Daily", April 20, 2006.
6. Charm offensive may win over US: scholars, "South China Morning Post", April 20, 2006.
7. See: Hu: China seeks peaceful development, "China Daily", April 22-23, 2006 and Howard French, Is it a "peaceful rise"? U.S. shouldn't bet on it, "International Herald Tribune", April 20, 2006.
8. Leaders hold "pragmatic, constructive" talks, "China Daily", April 21, 2006 and Bush faces the reality of China-US relations, "International Herald Tribune", April 22-23, 2006.
9. "1992 consensus" crucial to maintaining peace: Hu, "China Daily", April 17, 2006.
10. Ц.Батбаяр, БНХАУ-ын хөгжлийн шинэ үзэл баримтлал, "Өнөөгийн Хятад", 2006, №1, 6-8 тал.
11. М.Чимидцэеэ, Күнзийн соёл сэтгэлгээний өв хийгээд эдүгээ цаг, "Өнөөгийн Хятад", 2006, №1, 20-25-р тал.
12. In U.S., Hu is challenged, toasted, "Asian Wall Street Journal", April 24, 2006.
13. Ху Жинтао кайчи дуй Мэй вайзю синшидай, "Дунфан Ляован", 2006, №17, 14-17-р тал
14. US visit was fruitful, says FM, "China Daily", April 24, 2006.
15. A successful summit, http://english.peopledaily.com.cn/200604/26/eng20060426_261402.html
16. Sino-US cooperation shows signs of maturing, "China Daily", April 17, 2006.
17. Protester interrupts Hu's speech, "International Herald Tribune", April 21, 2006.
18. Hu seeks oil, and allies, in the Gulf, "International Herald Tribune", April 24, 2006.